



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар

А/2027

Мандалговь

ХУР-ДАН системийн тохижилтыг
хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж буй ХУР-ДАН системийн үйлчилгээний цэгийн тохижилтыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Түвшинжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Н.Мөнгөн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Ц.Хулан (Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга)

М.Чулуунболор (Төрийн цахим үйлчилгээний мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Т.Эрдэнэмандал (Алтан бэрс ХХК-ийн захирал)

2. Үйлчилгээний цэгийн тохижилтыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Түвшинжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

М.АНХБАЯР



4823100575